

БАТЛАВ
 МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
 Я. САРВАНГА
 Я. СОДБААТАР
 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

2021 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ, ӨДӨРЛӨГИЙН ХУВААРЬ

А/А	Нэгдсэн арга хэмжээний нэр		2021 он											
			1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	"Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагааг, ам эхгүйн нэгж, байгууллага айл өрхийн тал түймрийн аюулгүй байдлыг хангуулах" нэгдсэн арга хэмжээ	Хамтран ажиллах байгууллага	[Red]											
2	Өвөлжилт, хаваржилт хундрах болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ		[Dark Blue]									[Dark Blue]		
3	Шар усны үеэрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ				[Yellow]									
4	Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ							[Green]						
5	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таныулах өдөрлөг				[Blue]									
6	Гэмшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөрлөг												[Purple]	
7	Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөг				[Dark Blue]									

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА



**ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТ ХҮНДРЭХ БОЛОН ЗУДЫН АЮУЛААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Байгаль, цаг агаарын гаралтай аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг ард иргэд, малчин айл өрхүүдэд зохион байгуулж, болзошгүй байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоол, Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл нь эрх зүйн үндэс болно.

2.2. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад дээрх хууль тогтоомж, энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3. Энэхүү нэгдсэн арга хэмжээний хүрээнд ард иргэд, малчин айл өрхүүдэд болзошгүй цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

2.4. Ард иргэд, малчин айл өрхүүдэд сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгаа явуулах, гарын авлага, видео шторкыг албаны www.nema.gov.mn цахим хуудаснаас татаж авна.

**Гурав. Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах
бүрэлдэхүүн**

3.1. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гамшгаас урьдчилан сэргийлэх тасаг, нэгж.

3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын бүрэлдэхүүн.

3.3. Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цахилгаан, дулаан, усан хангамж, зам, гүүр дэд бүтэц хариуцсан бүтцийн нэгж.

3.4. Ус цаг уур, орчны шинжилгээний газар

3.5. Аймаг, нийслэлийн Авто тээврийн төв

3.6. Аймаг, нийслэлийн Цагдаагийн газар

3.7. АЗЗА ХК

Дөрөв. Хугацаа, хамрах хүрээ

4.1. Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний I шатыг 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 05 дугаар сарын 01, II шатыг 08 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд тус тус зохион байгуулна.

4.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны ард иргэдийн аюулгүй байдал, түлш эрчим хүчний байнгын хэвийн тогтвортой ажиллагааг хангуулах, мал сүргийг хамгаалах, зам давааны нэвтрүүлэх чадамжийг хангахад чиглэгдэнэ.

Тав. Зохион байгуулагдах үйл ажиллагаа

5.1. Мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг даргын захирамжаар томилох.

5.2. Аймаг, сумдын дулааны станц, цахилгаан эрчим хүчний байгууллагын өвөлжилтийн блэн байдлыг үнэлэх.

5.3. Цаг уур, орчны шинжилгээний газраас 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд гаргасан зудын эрсдэлийн үнэлгээний дагуу хариу арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулах.

5.3. Нэгдсэн арга хэмжээний хугацаанд сум, дүүрэг, баг, хороон дээр 5-аас доошгүй удаа өдөрлөг зохион байгуулах.

5.4. Аймаг, сум, дүүргийн цаг агаарын аюулт үзэгдлийн дуудлагаар ажиллах томилгоот алба хаагч, техник хэрэгсэл, алба мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг шалган зааварчлах.

5.5. Орон нутгийн зам, давааны нөхцөл байдалд үнэлгээ хийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах.

5.6. Цаг агаарын мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан тодруулж, өвөлжилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, малчид, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай хүргэх, түүний дотор "Багц мессеж"-ээр давтамжтайгаар хүргэх.

5.7. Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг орон нутгийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүртээмжтэй хүргэх.

5.8. Зохион байгуулсан арга хэмжээний дүн, мэдээг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын ангиллын сургалт хариуцсан мэргэжилтний nemasurqalt@gmail.com цахим хаягаар илтгэх хуудсаар ирүүлнэ.

Зургаа. Нэгдсэн арга хэмжээний үр дүн, зардал

6.1. Гамшгийн шуурхай удирдлагын газар, Гамшгаас урьдчилан сэргийлэх газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2. Улсын хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн тайланг Гамшгаас урьдчилан сэргийлэх газар нэгтгэн, Онцгой байдлын ерөнхий газрын даргад 2021 оны 11 дүгээр сарын 01-ний дотор танилцуулна. Тайлангийн хувийг Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд хүргүүлнэ.

6.3. Нэгдсэн арга хэмжээ явуулах зардлыг тухайн шатны Засаг даргын тамгын газрын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал, Онцгой байдлын газар, хэлтэс, Олон улсын байгууллага, хүмүүнлэгийн байгууллага, Төрийн болон төрийн бус байгууллагын гамшгаас урьдчилан сэргийлэхэд зориулан зардлаас тус тус санхүүжүүлнэ.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР